



МОНГОЛ УЛС
БАЯНХОНГОР АЙМГИЙН
ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗАР

310 дугаар байр, Лувсанданзанжанцангийн өргөн
чөлөө 3, Номгон 1 дүгээр баг, Баянхонгор сум,
Баянхонгор аймаг, 64101 Утас: (976) 70442273
Цахим шуудан: info@bayanhongor.gov.mn
Цахим хаяг: www.bayanhongor.gov.mn

2025-08-29 № 8/1045
танай _____ -ны № _____ -т

ТӨРИЙН БОЛОН ОРОН НУТГИЙН ӨМЧИЙН
БАЙГУУЛЛАГЫН ДАРГА НАРТ

Төрийн болон орон нутгийн өмчит байгууллагуудын 2025 оны хагас жилийн үйл ажиллагаанд хийсэн хяналт шинжилгээ, үнэлгээний тайлан, зөвлөмжийг хүргүүлэв.

Зөвлөмжийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөө боловсруулан хэрэгжүүлэхийг мэдэгдье.

Хавсралт хуудастай.

ХЯНАЛТ ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭНИЙ
ХЭЛТСИЙН ДАРГА  Т.ЭРДЭНЭБАТ



625271565



БАЯНХОНГОР АЙМГИЙН
ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗАР
ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭНИЙ ХЭЛТЭС
ЗӨВЛӨМЖ

2025 оны 08 сарын 28 өдөр

Дугаар 01

Номгон

Г Төрийн болон Орон нутгийн өмчийн Г
байгууллагуудын 2025 оны эхний хагас үйл
ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ
хийсэн тухай

Бодлогын баримт бичиг, хууль тогтоомж тогтоол шийдвэрийн хэрэгжилт, бодлого төлөвлөлт, үйл ажиллагааны гүйцэтгэл, үр дүнг хянах, үнэлэх, дүгнэлт, зөвлөмж өгөх, бодлого, үйл ажиллагааны үр нөлөө, сахилга, хариуцлагыг нэмэгдүүлэх зорилгоор Төрийн болон орон нутгийн өмчийн 11 байгууллагын 2025 оны эхний хагас жилийн үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийж дараах зөвлөмжийг хүргүүлж байна.

1.Бодлогын баримт бичгийн хэрэгжилтэд хийсэн хяналт-шинжилгээ, үнэлгээгээр үр дүнгүй, эрчимжүүлэх шаардлагатай гэж үнэлэгдсэн арга хэмжээнүүдийн үр дүнг нэмэгдүүлэх.

2.Аймгийн 2025 оны жилийн хөгжлийн төлөвлөгөөний хяналтад аваагүй заалтууд, байгууллагын гүйцэтгэлийн төлөвлөгөөний хэрэгжилтийн үнэлгээгээр үр дүнгүй, эрчимжүүлэх шаардлагатай гэж үнэлэгдсэн арга хэмжээ, хууль тогтоомж, тогтоол шийдвэр, аймгийн Засаг даргын захирамж, албан даалгаврын хэрэгжилт хангалтгүй, хэрэгжээгүй, хугацаа болоогүй заалт тус бүрийг хяналтад авч, хэрэгжилтийг бүрэн хангах арга хэмжээг авч хэрэгжүүлэх, удирдлага, зохион байгуулалтыг сайжруулж, сахилга хариуцлагыг дээшлүүлэх.

3.Байгууллагын гүйцэтгэлийн төлөвлөгөөний хэрэгжилтийг зорилт, арга хэмжээний шалгуур үзүүлэлт, хүрэх түвшинд нийцүүлэн одоогийн суурь түвшинээс хүрсэн түвшингийн өөрчлөлтөөр тодорхой, оновчтой, үр дүнг илэрхийлэхүйц, хэмжих болохуйц байдлаар салбарын албан ёсны статистик үзүүлэлтэд суурилж, санхүүжилт, бодит үр дүнд тулгуурлан тайлагнах.

4.Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай хууль, Засгийн газрын 2022 оны 352 дугаар тогтоолоор батлагдсан “Нээлттэй мэдээллийг ил тод байлгах болон ил тод байдлын шалгуур үзүүлэлт тогтоох, үнэлгээ хийх журам”-ыг тус тус баримтлан ажиллаж Shilen.gov.mn цахим системд мэдээллэсэн мэдээлэлтэй,

642341104

уялдуулан байгууллагын албан ёсны цахим хуудас, ил тод байдлын самбар, бусад сувгуудаар хэрхэн ил тод мэдээлж, хэдэн хүнд хүргэсэн, мэдээллийг ямар давтамжтай шинэчилсэн, ямар эх сурвалжаас тухайн мэдээллийг дэлгэрэнгүй бүрэн авах боломжтой зэрэг үр дүнг тайланд тавих шаардлагад нийцүүлэн тайлагнах.

5.Хяналт-шинжилгээ, үнэлгээний зөвлөмжийг хэрэгжүүлэх нарийвчилсан төлөвлөгөөг боловсруулахдаа хэрэгжилт хангалтгүй, хэрэгжээгүй, хугацаа болоогүй заалт тус бүрийг тусгах, холбогдох албан тушаалтанд хариуцуулах, хэрэгжилтийг цахим тайланд файлаар хавсарган ирүүлэх.

6.Оны эхний хагас жилийн үйл ажиллагааны үр дүнгийн үнэлгээгээр “50 хувь”-иас доош үнэлгээ авсан Автотээврийн төв, Баянхонгор үйлдвэржилт хөгжлийн корпораци, Төрийн цахим үйлчилгээний хэлтэс нь үйл ажиллагаагаа сайжруулах төлөвлөгөөг тус тус боловсруулан хэрэгжүүлж, үр дүнг эрчимжүүлэн үйл ажиллагааны үр дүн, чанарыг нэмэгдүүлэх зохион байгуулалтын арга хэмжээ авч ажиллах.

Зөвлөмжийн хэрэгжилтийг 2025 оны 12 дугаар сарын 25-ны дотор аймгийн Хяналт-шинжилгээ, үнэлгээний цахим санд тайлагнахыг зөвлөж байна.

ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭНИЙ
ХЭЛТСИЙН ДАРГА Т.ЭРДЭНЭБАТ



**ТӨРИЙН БОЛОН ОРОН НУТГИЙН ӨМЧИЙН БАЙГУУЛЛАГУУДЫН
2025 ОНЫ ЭХНИЙ ХАГАС ЖИЛИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНД
ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭ ХИЙСЭН ТАЙЛАН**

2025 оны 08 дугаар сарын 20

Номгон

Нэг.Хяналт-шинжилгээ, үнэлгээний зорилго, аргачлал, хамрах хүрээ:

Төрийн болон Орон нутгийн өмчийн 11 байгууллагын бодлогын баримт бичиг, хууль тогтоомж тогтоол шийдвэрийн хэрэгжилт, бодлого төлөвлөлт, үйл ажиллагааны гүйцэтгэл, үр дүнг хянах, үнэлэх, дүгнэлт, зөвлөмж өгөх, бодлого, үйл ажиллагааны үр нөлөө, сахилга, хариуцлагыг нэмэгдүүлэх, зорилгоор 2025 оны эхний хагас жилийн үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээг хийлээ.

Бодлогын баримт бичгийн хэрэгжилт, байгууллагын үйл ажиллагааг үнэлэхдээ Аймгийн Засаг даргын 2022 оны А/286 дугаар захирамжаар баталсан “Бодлогын баримт бичиг, хууль тогтоомж, тогтоол шийдвэрийн хэрэгжилт, нутгийн захиргааны болон орон нутгийн өмчийн байгууллагын үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх журам”-ыг удирдлага болгов.

Бодлогын баримт бичгийн хэрэгжилтийн үнэлгээнд:

- Аймгийн 2025 оны хөгжлийн төлөвлөгөөний биелэлт;
- Дэд хөтөлбөр, арга хэмжээний төлөвлөгөөний хэрэгжилт;

Хууль тогтоомж, тогтоол шийдвэрийн хэрэгжилтийн үнэлгээнд:

- Хууль тогтоомж, тогтоол шийдвэрийн хэрэгжилт;
- Аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын тогтоол, шийдвэр;
- Аймгийн Засаг даргын захирамж, албан даалгаврын хэрэгжилт;
- Зөвлөмжийн хэрэгжилт;

Байгууллагын чиг үүргийн үзүүлэлтийн хэрэгжилтийн үнэлгээнд:

- Байгууллагын гүйцэтгэлийн төлөвлөгөө, тайлан;
- Төрийн албан хаагчийн сургалт, ажиллах нөхцөл, нийгмийн баталгааны хөтөлбөрийн биелэлт;
- Байгууллагын ил тод байдлын үнэлгээ;
- Архив, албан хэрэг хөтлөлтийн үнэлгээ
- Шилэн данс
- Байгууллагын тэргүүлэх ач холбогдолтой шалгуур үзүүлэлт зэрэг 13 тайланг

хянаж, үнэлгээг тооцсон.

Бодлогын баримт бичгийн хэрэгжилт, захиргааны байгууллагын үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийхдээ тус байгууллагаас цаасан болон

цахим хэлбэрээр ирүүлсэн тайлан, байгууллагын цахим хуудас зэрэгтэй харьцуулалт хийж үнэлсэн болно.

Хууль тогтоомж, тогтоол шийдвэрийн хэрэгжилт, Аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын тогтоол, шийдвэр, Аймгийн Засаг даргын захирамж, Албан даалгаврын хэрэгжилт, Дэд хөтөлбөр, арга хэмжээний төлөвлөгөөний хэрэгжилт, Байгууллагын гүйцэтгэлийн төлөвлөгөөний тайлан, Төрийн албан хаагчийн сургалт, ажиллах нөхцөл, нийгмийн баталгааны хөтөлбөрийн биелэлт, Байгууллагын ил тод байдлын үнэлгээ, Байгууллагын тэргүүлэх ач холбогдолтой шалгуур үзүүлэлт, Зөвлөмжийн хэрэгжилт зэрэг 9 тайланг Баянхонгор аймгийн Хяналт-шинжилгээ, үнэлгээний мэдээллийн цахим сангаар хүлээн авч үнэлсэн.

Дээрх цахим тайлангуудын хэрэгжилтийн дэлгэрэнгүй үнэлгээг <http://bayankhongor.igovernment.mn> цахим хуудаснаас үзэх боломжтой.

Аймгийн жилийн хөгжлийн төлөвлөгөөний биелэлт, Байгууллагын тэргүүлэх ач холбогдолтой шалгуур үзүүлэлтийн үнэлгээг тухайн байгууллагаас цаасаар ирүүлсэн тайланд үндэслэн дүгнэв.

Архив, албан хэрэг хөтлөлтийн үнэлгээг аймгийн Засаг даргын Тамгын газрын Төрийн архивын тасгийн үнэлгээгээр, Шилэн дансны үнэлгээг Санхүүгийн хяналт, дотоод аудитын албаны үнэлгээгээр дүгнэлээ.

Хоёр.Хяналт-шинжилгээ, үнэлгээний дүн:

Төрийн болон Орон нутгийн өмчийн байгууллагуудын 2025 онд хяналтад авч хэрэгжүүлэн тайлагнасан ажил, арга хэмжээний үнэлгээг тайлан тус бүрээр танилцуулбал:

2.1.Аймгийн жилийн хөгжлийн төлөвлөгөөний хэрэгжилтийн үнэлгээ:

Аймгийн 2025 оны хөгжлийн төлөвлөгөөний хэрэгжилтийг Төрийн болон Орон нутгийн өмчийн 10 байгууллага ирүүлэхээс 3 байгууллага ирүүлж, байгууллагуудын дундаж үнэлгээ 22,3 хувьтай үнэлэгдснээс “Баянхонгор тохижилт” ОНӨТБ “Үр дүнтэй”, “Бөөнцагаан-Орог нуурын сав газрын захиргаа”, “Жаргалтай амьдрал” сэтгэц нийгмийн сэргээн засах эмчилгээний төв “Тодорхой үр дүнд хүрсэн” гэж үнэлэгдсэн бол “Автотээврийн төв” 5 заалт, “Баянхонгор үйлдвэржилт хөгжлийн корпораци” 2 заалт, “Сум дундын ойн анги” ОНӨААТҮГ 1 заалт, “Цэвэр хот” ОНӨААТҮГ 2 заалт, “Чандмань Баянхонгор” ХК 1 заалт, “Баянхонгор Эрчим хүч, цахилгаан түгээх” ХХК 1 заалт, “Төрийн цахим үйлчилгээний хэлтэс” 3 заалтын хэрэгжилтийг тайлагнаагүй байна.

“Баянхонгор тохижилт” ОНӨТБ 6 заалт тайлагнахаас 3 заалт, “Бөөнцагаан-Орог нуурын сав газрын захиргаа” 9 заалт тайлагнахаас 7 заалт, “Жаргалтай

амьдрал” сэтгэц нийгмийн сэргээн засах эмчилгээний төв 2 заалт тайлагнахаас 1 заалтыг хяналтад авч тайлагнасан, бусад байгууллагууд холбогдох ажил, арга хэмжээний заалтыг хяналтад аваагүй, заалтыг зөрүүлж хяналтад авсан зэрэг алдаанууд байна.

Хүснэгт 1. Аймгийн жилийн хөгжлийн төлөвлөгөөний хэрэгжилтийн үнэлгээний дүн:

Төрийн болон Орон нутгийн өмчийн байгууллагууд	Тайлагнаагүй	Дундаж үнэлгээ (%)
1	2	3
Автотээврийн төв	ирүүлээгүй	0%
Баянхонгор тохижилт ОНӨТБ		100%
Баянхонгор Эрчим хүч, цахилгаан түгээх ХХК	ирүүлээгүй	0%
Бөөнцагаан-Орог нуурын сав газрын захиргаа		73,3%
“Жаргалтай амьдрал” сэтгэц нийгмийн сэргээн засах эмчилгээний төв		50%
Их Богдын байгалийн цогцолборт газрын хамгаалалтын захиргаа	-	-
Сум дундын ойн анги ОНӨААТҮГ	ирүүлээгүй	0%
Цэвэр хот ОНӨААТҮГ	ирүүлээгүй	0%
Чандмань Баянхонгор ХК	ирүүлээгүй	0%
Баянхонгор үйлдвэржилт хөгжлийн корпораци	ирүүлээгүй	0%
Төрийн цахим үйлчилгээний хэлтэс	ирүүлээгүй	0%
Нийт дүн	-	22,3%

2.2. Дэд хөтөлбөрийн хэрэгжилтийн үнэлгээ:

Аймгийн дэд хөтөлбөрүүдээс давхардсан тоогоор 12 дэд хөтөлбөрийн 16 арга хэмжээг Төрийн болон Орон нутгийн өмчийн 9 байгууллага дунджаар 84.7 хувьтай хэрэгжүүлсэн байна.

“Их Богдын байгалийн цогцолборт газрын хамгаалалтын захиргаа” “Үр дүнтэй”, “Автотээврийн төв”, “Баянхонгор тохижилт” ОНӨТБ, “Бөөнцагаан-Орог нуурын сав газрын захиргаа”, “Жаргалтай амьдрал” сэтгэц нийгмийн сэргээн засах эмчилгээний төв, “Сум дундын ойн анги” ОНӨААТҮГ, “Цэвэр хот” ОНӨААТҮГ, “Чандмань Баянхонгор” ХК “Тодорхой үр дүнд хүрсэн”, “Баянхонгор Эрчим хүч, цахилгаан түгээх” ХХК “Эрчимжүүлэх шаардлагатай” гэж үнэлэгдсэн байна.

Хүснэгт 2. Дэд хөтөлбөрийн хэрэгжилтийн үнэлгээний дүн:

Төрийн болон Орон нутгийн өмчийн байгууллагууд	Хөтөлбөрийн тоо	Арга хэмжээний тоо	Үнэлгээ (арга хэмжээний тоогоор)				Тайлагнаагүй	Дундаж үнэлгээ (%)
			Үр дүнтэй	Тодорхой үр дүнд хүрсэн	Эрчимжүүлэх шаардлагатай	Үр дүнгүй		
1	2	3	4	5	6	7	8	9
Автотээврийн төв	1	1		1	-		-	90%
Баянхонгор тохижилт ОНӨТБ	2	3	2	1	-		-	97.5%
Баянхонгор Эрчим хүч, цахилгаан түгээх ХХК	1	2	1		-	1	-	50%
Бөөнцагаан-Орог нуурын сав газрын захиргаа	2	3		3	-		-	80%
"Жаргалтай амьдрал" сэтгэц нийгмийн сэргээн засах эмчилгээний төв	1	1		1	-		-	90%
Их Богдын байгалийн цогцолборт газрын хамгаалалтын захиргаа	1	1	1		-		-	100%
Сум дундын ойн анги ОНӨААТҮГ	1	1		1	-		-	90%
Цэвэр хот ОНӨААТҮГ	2	3	2	1	-		-	95%
Чандмань Баянхонгор ХК	1	1		1	-		-	70%
Баянхонгор үйлдвэржилт хөгжлийн корпораци	-	-			-		-	
Төрийн цахим үйлчилгээний хэлтэс	-	-			-		-	
Нийт дүн	12	16	6	9	-	1	-	84.7%
Үнэлгээнд эзлэх хувь		100%	37.5	56.25	-	6.25	-	

2.3.Хууль тогтоомж, тогтоол шийдвэрийн хэрэгжилтийн үнэлгээ:

Монгол Улсын хууль, Улсын Их хурлын байнгын хорооны тогтоол, Ерөнхийлөгчийн зарлиг, Үндэсний аюулгүй байдлын зөвлөлийн зөвлөмж, Засгийн газрын тогтоол, Засгийн газрын хуралдааны тэмдэглэл, Засгийн газрын албан даалгавраар үүрэгжүүлэн өгсөн нийт 40 шийдвэр, 71 заалтын хэрэгжилт дунджаар 89,5 хувиар үнэлэгдэв.

Хүснэгт 3. Хууль тогтоомж, тогтоол шийдвэрийн хэрэгжилтийн үнэлгээний дүн:

Төрийн болон Орон нутгийн өмчийн байгууллагууд	Шийдвэрийн тоо	Заалтын тоо	Үнэлгээ (арга хэмжээний тоогоор)			Дундаж үнэлгээ (%)
			Хэрэгжсэн	Хэрэгжээгүй	Хугацаа болоогүй	
1	2	3	4	5	8	10
Автотээврийн төв	2	5	3	2	-	60%
Баянхонгор тохижилт ОНӨТБ	3	6	5	1	-	83%

Баянхонгор Эрчим хүч, цахилгаан түгээх ХХК	3	6	6	-	-	100%
Бөөнцагаан-Орог нуурын сав газрын захиргаа	5	9	6	1	2	86%
“Жаргалтай амьдрал” сэтгэц нийгмийн сэргээн засах эмчилгээний төв	3	6	6	-	-	100%
Их Богдын байгалийн цогцолборт газрын хамгаалалтын захиргаа	3	6	6	-	-	100%
Сум дундын ойн анги ОНӨААТҮГ	5	8	8	-	-	100%
Цэвэр хот ОНӨААТҮГ	3	6	6	-	-	100%
Чандмань Баянхонгор ХК	3	6	4	1	1	80%
Төрийн цахим үйлчилгээний хэлтэс	10	13	6	1	6	86%
Баянхонгор үйлдвэржилт хөгжлийн корпораци ХХК	-	-	-	-	-	-
Нийт дүн	40	71	56	6	9	89,5%
Үнэлгээнд эзлэх хувь		100	78,9%	8,5%	12,6%	

2.4.Аймгийн Иргэдийн төлөөлөгчдийн хурлын тогтоол, шийдвэрийн хэрэгжилтийн үнэлгээ:

Аймгийн Иргэдийн төлөөлөгчдийн хурлын 12 тогтоол, шийдвэрийн 12 заалтыг Төрийн болон Орон нутгийн өмчийн 11 байгууллага дунджаар 81,81 хувьтай хэрэгжүүлсэн байна.

Байгууллагуудаас 9 байгууллага 100% буюу “Үр дүнтэй” гэж үнэлэгдсэн бол “Жаргалтай амьдрал” сэтгэц нийгмийн сэргээн засах эмчилгээний төв “Хугацаа болоогүй” гэж тайлагнаж, Төрийн цахим үйлчилгээний хэлтэс хэрэгжүүлээгүй байна.

Хүснэгт 4. Аймгийн ИТХ-ын тогтоол, шийдвэрийн хэрэгжилтийн үнэлгээний дүн:

Төрийн болон Орон нутгийн өмчийн байгууллагууд	Шийдвэрийн тоо	Заалтын тоо	Үнэлгээ (арга хэмжээний тоогоор)			Үнэлгээ өгөгдөөгүй	Дундаж үнэлгээ (%)
			Хэрэгжсэн	Хэрэгжээгүй	Хугацаа болоогүй		
1	2	3	4	5	6	7	8
Автотээврийн төв	1	1	1			-	100%
Баянхонгор тохижилт ОНӨТБ	1	1	1			-	100%
Баянхонгор Эрчим хүч, ЦТ ХХК	1	1	1			-	100%
Бөөнцагаан-Орог нуурын сав газрын захиргаа	2	2	2			-	100%
“Жаргалтай амьдрал” сэтгэц нийгмийн сэргээн засах эмчилгээний төв	1	1			1	-	-
Их Богдын байгалийн цогцолборт газрын хамгаалалтын захиргаа	1	1	1			-	100%
Сум дундын ойн анги ОНӨААТҮГ	1	1	1			-	100%
Цэвэр хот ОНӨААТҮГ	1	1	1			-	100%
Чандмань Баянхонгор ХК	1	1	1			-	100%
Төрийн цахим үйлчилгээний хэлтэс	1	1		1		-	0%
Баянхонгор үйлдвэржилт хөгжлийн корпораци ХХК	1	1	1			-	100%
Нийт дүн	12	12	10	1	1	-	81,81%
Үнэлгээнд эзлэх хувь		100	83,34%	8,33%	8,33%	-	

2.5. Аймгийн Засаг даргын захирамж, албан даалгаврын хэрэгжилтийн үнэлгээ:

Аймгийн Засаг даргын захирамж, албан даалгаврын хэрэгжилтийн тайланд улирал тутамд үнэлгээг хийсэн. Тайлант оны эхний хагас жилийн байдлаар 107 захирамж, албан даалгаврын 192 заалтыг Төрийн болон Орон нутгийн өмчийн 11 байгууллага “Тодорхой үр дүнд хүрсэн” буюу дундаж хэрэгжилт 87,45 хувьтай хэрэгжүүлсэн байна.

Хүснэгт 5. Аймгийн Засаг даргын захирамж, албан даалгаврын хэрэгжилтийн үнэлгээний дүн:

Төрийн болон Орон нутгийн өмчийн байгууллагууд	Шийдвэрийн тоо	Заалтын тоо	Үнэлгээ (арга хэмжээний тоогоор)			Үнэлгээ өгөгдөөгүй	Дундаж үнэлгээ (%)
			Хэрэгжсэн	Хэрэгжээгүй	Хугацаа болоогүй		
1	2	3	4	5	6	7	8
Автотээврийн төв	10	16	11	3	2	-	79%
Баянхонгор тохижилт ОНӨТБ	10	20	20			-	100%
Баянхонгор Эрчим хүч, цахилгаан түгээх ХХК	10	18	17		1	-	100%
Бөөнцагаан-Орог нуурын сав газрын захиргаа	10	16	14		2	-	100%
“Жаргалтай амьдрал” сэтгэц нийгмийн сэргээн засах эмчилгээний төв	10	16	14		2	-	100%
Их Богдын байгалийн цогцолборт газрын хамгаалалтын захиргаа	9	15	14		1	-	100%
Сум дундын ойн анги ОНӨААТҮГ	10	18	17		1	-	100%
Цэвэр хот ОНӨААТҮГ	10	20	17		3	-	100%
Чандмань Баянхонгор ХК	11	25	20	4	1	-	83%
Баянхонгор аймгийн Төрийн цахим үйлчилгээний хэлтэс	8	14				14	0%
Баянхонгор үйлдвэржилт хөгжлийн корпораци ХХК	9	14	12		2	-	100%
Нийт дүн	107	192	156	7	15	14	87,45%
Үнэлгээнд эзлэх хувь		100	81.25%	3.64%	7.8%	7.3%	

2.6. Зөвлөмжийн хэрэгжилтийн үнэлгээ:

Бодлогын баримт бичиг, хууль тогтоомжийн хэрэгжилт, байгууллагын үйл ажиллагаанд 2024 оны жилийн эцсийн үйл ажиллагаанд хийсэн хяналт-шинжилгээ, үнэлгээний дагуу өгсөн зөвлөмжийн хэрэгжилтийг цахим системээр үнэлсэн бөгөөд 11 байгууллага 100% тайлагнаж дундаж хэрэгжилт 71,42 хувьтай үнэлэгдсэн байна.

Зөвлөмжийн хэрэгжилт 71,42 хувьтай үнэлэгдсэн нь өмнөх оны мөн үетэй харьцуулахад 6,92 хувиар өссөн, цагалбарын дагуу тайлагнасан ахиц гарсан үзүүлэлттэй байна.

Хүснэгт 6. Зөвлөмжийн хэрэгжилтийн үнэлгээний дүн:

Төрийн болон Орон нутгийн өмчийн байгууллагууд	Шийдвэрийн тоо	Заалтын тоо	Үнэлгээ (арга хэмжээний тоогоор)				Хугацаа болоогүй	Үнэлгээ өгөгдөөгүй	Дундаж үнэлгээ (%)
			Бүрэн хэрэгжсэн	Хэрэгжих шатанд	Хэрэгжилт хангалтгүй	Хэрэгжээгүй			
1	2	3	4	5	6	7	8	9	
Автотээврийн төв	1	7	-		3	4	-	-	12,86%
Баянхонгор тохижилт ОНӨТБ	1	6	5		1		-	-	88,33%
Баянхонгор Эрчим хүч, ЦТ ХХК	1	6	-		5	1	-	-	25%
Бөөнцагаан-Орог нуурын сав газрын захиргаа	1	6	4		2		-	-	76,67%
“Жаргалтай амьдрал” сэтгэц нийгмийн сэргээн засах эмчилгээний төв	1	6	6				-	-	100%
Их Богдын байгалийн цогцолборт газрын хамгаалалтын захиргаа	1	6	6				-	-	100%
Сум дундын ойн анги ОНӨААТҮГ	1	7	7				-	-	100%
Цэвэр хот ОНӨААТҮГ	1	6	4	1		1	-	-	78,33%
Чандмань Баянхонгор ХК	1	6	3	2	1		-	-	78,33%
Төрийн цахим үйлчилгээний хэлтэс	1	7	2	1	1	3	-	-	42,86%
Баянхонгор үйлдвэржилт хөгжлийн корпораци ХХК	1	6	4	1	1		-	-	83,33%
Нийт дүн	11	69	41	5	14	9	-	-	71,42%
Үнэлгээнд эзлэх хувь		100%	59,42%	7,24%	20,3%	13,04%			

2.7. Байгууллагын гүйцэтгэлийн тайлангийн үнэлгээ:

Төрийн болон Орон нутгийн өмчийн байгууллагууд 2025 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөний тайланг 100 хувь цахим системээр тайлагнасан хэдий ч “Авто тээврийн төв” нэгдүгээр улирлын биелэлт ирүүлсэн, “Сум дундын ойн анги” ОНӨААТҮГ, “Төрийн цахим үйлчилгээний хэлтэс” гарын үсэг тамга тэмдэгээр баталгаажуулаагүй тайлан ирүүлснийг үнэлэх боломжгүй гэж үзсэн.

“Баянхонгор Эрчим хүч, цахилгаан түгээх” ХХК хэрэгжилт үнэлэх боломжгүй тайлбарыг албан бичгээр ирүүлсэн байна.

Байгууллагын гүйцэтгэлийн төлөвлөгөө нь тухайн байгууллагын үйл ажиллагааны үндсэн баримт бичиг бөгөөд тайланг хянан үзэхэд тайлагнасан 7 байгууллага “Тодорхой үр дүнд хүрсэн” гэж үнэлэгдлээ.

Хэрэгжилтийн дундаж үнэлгээ 57.1 хувьтай байгаа нь өнгөрсөн оны мөн үетэй харьцуулахад 13.1 хувиар буурсан байна.

Хүснэгт 7. Байгууллагуудын гүйцэтгэлийн тайлангийн үнэлгээний дүн:

Төрийн болон Орон нутгийн өмчийн байгууллагууд	Арга хэмжээ	Үнэлгээ					Дундаж хувь
		Үүний дотор /Арга хэмжээний тоо/					
		Үр дүнтэй	Тодорхой үр дүнд хүрсэн	Эрчимжүүлэх шаардлагатай	Үр дүнгүй	Хугацаа болоогүй	
1	3	4	5	6	7	8	9
Автотээврийн төв	55	-				55	0%
Баянхонгор тохижилт ОНӨТБ	38	26	3	2	1	6	89.69%
Баянхонгор Эрчим хүч, цахилгаан түгээх ХХК	20	-				20	-
Бөөнцагаан-Орог нуурын сав газрын захиргаа	47	32	8	5	2		85.32%
“Жаргалтай амьдрал” сэтгэц нийгмийн сэргээн засах эмчилгээний төв	24	14	9	1			85.83%
Их Богдын байгалийн цогцолборт газрын хамгаалалтын захиргаа	22	12	5	3		2	85%
Сум дундын ойн анги ОНӨААТҮГ	30	-				30	0%
Цэвэр хот ОНӨААТҮГ	39	25	8	6			85.64%
Чандмань Баянхонгор ХК	36	11	9	3	3		72.31%
Төрийн цахим үйлчилгээний хэлтэс	23	-				23	0%
Баянхонгор үйлдвэржилт хөгжлийн корпораци	32	9	12	7	3	1	67.42%
Нийт дүн	366	129	54	27	117	39	57.1%
Үнэлгээнд эзлэх хувь	100	35.24%	14.76%	7.3%	32%	10.7%	

2.8.Төрийн албан хаагчийн сургалт, ажиллах нөхцөл, нийгмийн баталгааны хөтөлбөрийн хэрэгжилтийн үнэлгээ:

Төрийн болон Орон нутгийн өмчийн байгууллагууд Төрийн албан хаагчийн сургалт, ажиллах нөхцөл, нийгмийн баталгааны хөтөлбөрийн хэрэгжилтийг дунджаар 71.55 хувьтай дүгнэлээ.

Энэ нь өнгөрсөн оны мөн үетэй харьцуулахад 4.16 хувиар буурсан үзүүлэлттэй байна.

Байгууллагуудын 20 хувь нь “Үр дүнтэй”, 45 хувь нь “Тодорхой үр дүнд” хүрсэн, 27 хувь нь “Эрчимжүүлэх шаардлагатай” гэж үнэлэгдсэн бол “Баянхонгор

үйлдвэржилт хөгжлийн корпораци” ХХК тайлангийн хэрэгжилтийг ирүүлээгүй байна.

Хүснэгт 8. Төрийн албан хаагчийн сургалт, ажиллах нөхцөл, нийгмийн баталгааны хөтөлбөрийн хэрэгжилтийн үнэлгээний дүн:

Байгууллагын нэр	Хэрэгжүүлсэн арга хэмжээний тоо	Үнэлгээ (арга хэмжээний тоогоор)					Дундаж үнэлгээ (%)
		Үр дүнтэй	Тодорхой үр дүнд хүрсэн	Эрчимжүүлэх шаардлагатай	Үр дүнгүй	Тайлагнаагүй	
1	2	3	4	5	6	7	8
Автотээврийн төв	7	4		1	2	-	61.43%
Баянхонгор тохижилт ОНӨТБ	7	5		1	1	-	75.71%
Баянхонгор Эрчим хүч, цахилгаан түгээх ХХК	7	6			1	-	85.71%
Бөөнцагаан-Орог нуурын сав газрын захиргаа	7	5			2	-	71.43%
“Жаргалтай амьдрал” сэтгэц нийгмийн сэргээн засах эмчилгээний төв	7	7				-	100%
Их Богдын байгалийн цогцолборт газрын хамгаалалтын захиргаа	7	5		1	1	-	75.71%
Сум дундын ойн анги ОНӨААТҮГ	7	6			1	-	85.71%
Цэвэр хот ОНӨААТҮГ	7	7				-	100%
Чандмань Баянхонгор ХК	7	4		2	1	-	68.57%
Төрийн цахим үйлчилгээний хэлтэс	7	3	2		2	-	62.86%
Баянхонгор үйлдвэржилт хөгжлийн корпораци	7	-			7	-	-
Нийт дүн	77	52	2	5	18		71.55%
Үнэлгээнд эзлэх хувь	100%	67.53%	2.6%	6.5%	23.37%		

2.9. Байгууллагын ил тод байдлын шалгуур үзүүлэлтийн үнэлгээ:

Байгууллагын ил тод байдлыг “Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай” хуульд заасан үндсэн 5 төрлийн 46 мэдээлэл тус бүрээр хянан үзэхэд байгууллагуудын дундаж үнэлгээ 58.6 хувьтай байна. Байгууллагуудын 27 хувь буюу “Баянхонгор Эрчим хүч, цахилгаан түгээх” ХХК, “Төрийн цахим үйлчилгээний хэлтэс” 91.54-98.29 хувиар “Бүрэн хэрэгжсэн”, “Их Богдын байгалийн цогцолборт газрын хамгаалалтын захиргаа”, “Баянхонгор тохижилт” ОНӨТБ, “Жаргалтай амьдрал” сэтгэц нийгмийн сэргээн засах эмчилгээний төв, “Чандмань Баянхонгор” ХК “Хэрэгжих шатанд” гэж дүгнэгдсэн бол бусад байгууллагууд 28.61-41.74 хувиар “Хэрэгжилт хангалтгүй” гэж дүгнэгдсэн.

Шалгуур үзүүлэлтийг байгууллагын албан ёсны цахим хуудас, ил тод байдлын самбар, бусад сувгуудаар хэрхэн ил тод мэдээлж, хэдэн хүнд хүргэсэн, мэдээллийг ямар давтамжтай шинэчилсэн, ямар эх сурвалжаас тухайн мэдээллийг дэлгэрэнгүй бүрэн авах боломжтой талаар тайлагнах, Shilen.gov.mn цахим системд мэдээллэсэн мэдээлэлтэй уялдуулах байтал тухайн заалтын хүрээнд зохион байгуулсан ажлыг тайлагнасан дутагдал давтагдсаар байна.

Хүснэгт 9. Байгууллагын ил тод байдлын шалгуур үзүүлэлтийн үнэлгээний дүн:

Төрийн болон Орон нутгийн өмчийн байгууллагууд	Шийдвэрийн тоо	Үнэлгээ (арга хэмжээний тоогоор)					Тайлагнаагүй	Дундаж үнэлгээ (%)
		Бүрэн хэрэгжсэн	Хэрэгжих шатанд	Хэрэгжилт хангалтгүй	Хэрэгжээгүй	Хугацаа болоогүй үнэлэгдээгүй		
1	2	3	4	5	6	7	8	9
Автотээврийн төв	46	-	10	-	7	29	-	41.18%
Баянхонгор тохижилт ОНӨТБ	46	9	11	6	4	16	-	61.67%
Баянхонгор Эрчим хүч, цахилгаан түгээх ХХК	46	32	4	3	-	7	-	91.54%
Бөөнцагаан-Орог нуурын сав газрын захиргаа	46	-	5	18	3	20	-	34.23%
"Жаргалтай амьдрал" сэтгэц нийгмийн сэргээн засах эмчилгээний төв	46	5	11	4	4	22	-	57.92%
Их Богдын байгалийн цогцолборт газрын хамгаалалтын захиргаа	46	14	11	-	-	21	-	86.80%
Сум дундын ойн анги ОНӨААТҮГ	46	2	10	2	9	23	-	41.74%
Цэвэр хот ОНӨААТҮГ	46	4	3	14	15	10	-	28.61%
Чандмань Баянхонгор ХК	46	10	9	7	1	19	-	68.15%
Баянхонгор үйлдвэржилт хөгжлийн корпораци	46	2	12	-	16	16	-	34.67%
Төрийн цахим үйлчилгээний хэлтэс	46	33	2	-	-	11	-	98.29%
Нийт	506	111	88	54	59	194	-	58.61%
Үнэлгээнд эзлэх хувь	100	22%	17.4%	10.6%	11.66%	38.34%		

2.10. Архив, албан хэрэг хөтлөлтийн үнэлгээ:

Байгууллагын архив, албан хэрэг хөтлөлтийн үйл ажиллагааны үнэлгээ 66 хувьтай үнэлэгдэж, өнгөрсөн оны мөн үеийнхээс 16 хувиар ахисан байна.

“Автотээврийн төв”, “Жаргалтай амьдрал” сэтгэц нийгмийн сэргээн засах эмчилгээний төв “О” хувьтай үнэлэгдсэн бол “Төрийн цахим үйлчилгээний хэлтэс” үнэлэгдээгүй байна.

Хүснэгт 10. Байгууллагын архивын үнэлгээ:

Д/д	Төрийн болон Орон нутгийн өмчийн байгууллагууд	Архив, албан хэрэг хөтлөлтийн үнэлгээ
1	2	3
1	Автотээврийн төв	0%
2	Баянхонгор тохижилт ОНӨТБ	80%
3	Баянхонгор Эрчим хүч, цахилгаан түгээх ХХК	80%
4	Бөөнцагаан-Орог нуурын сав газрын захиргаа	100%
5	“Жаргалтай амьдрал” сэтгэц нийгмийн сэргээн засах эмчилгээний төв	0%
6	Их Богдын байгалийн цогцолборт газрын хамгаалалтын захиргаа	80%
7	Сум дундын ойн анги ОНӨААТҮГ	80%
8	Цэвэр хот ОНӨААТҮГ	80%
9	Чандмань Баянхонгор ХК	80%
10	Баянхонгор үйлдвэржилт хөгжлийн корпораци	80%
11	Төрийн цахим үйлчилгээний хэлтэс	-
Дундаж үнэлгээ		66%

2.11. Байгууллагын тэргүүлэх ач холбогдолтой арга хэмжээ:

Төрийн болон Орон нутгийн өмчит байгууллагуудын тэргүүлэх ач холбогдолтой арга хэмжээний шалгуур үзүүлэлтийн тайлангийн дундаж үнэлгээ 81.72% хувьтай буюу “Тодорхой үр дүнд хүрсэн” гэж дүгнэгдсэн ба өнгөрсөн оны мөн үетэй харьцуулахад хэрэгжилт 39.72 хувиар ахисан үзүүлэлттэй байна.

Хэрэгжилтийг “Автотээврийн төв”, “Баянхонгор тохижилт” ОНӨТБ, “Баянхонгор Эрчим хүч, цахилгаан түгээх” ХХК, “Бөөнцагаан-Орог нуурын сав газрын захиргаа”, “Жаргалтай амьдрал” сэтгэц нийгмийн сэргээн засах эмчилгээний төв, “Их богдын байгалийн цогцолборт газрын хамгаалалтын захиргаа”, “Сум дундын ойн анги” ОНӨААТҮГ, “Цэвэр хот” ОНӨААТҮГ, “Чандмань Баянхонгор” ХК, “Баянхонгор үйлдвэржилтийн корпораци” ХХК ОНӨҮГазрууд ирүүлсэн бол “Төрийн цахим үйлчилгээний хэлтэс” ирүүлээгүй байна.

Байгууллагуудын тэргүүлэх ач холбогдолтой арга хэмжээний хэрэгжилтийг үнэлэх шалгуур үзүүлэлтийн гүйцэтгэлд хийсэн хяналт шинжилгээ, үнэлгээний үр дүнгээр:

Аж ахуйн нэгжийг цахилгаан эрчим хүчээр тасралтгүй хангахын тулд 2025 оны төлөвлөгөөт үзлэг хяналт шалгалтыг хийж гэнэтийн болон байгалийн давагдашгүй хүчин зүйлээс урьдчилан сэргийлэх ажлыг шуурхай зохион байгуулан, 15 чиглэлийн хүрээнд хяналт шалгалтыг гүйцэтгэж, 44 зөрчил илрүүлж, илэрсэн зөрчлийг 100 хувь арилган өвөлжилтийн бэлэн байдлыг хангасан.

Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар 14 тэрбум төгрөгийн санхүүжилттэй Баянхонгор аймгийн цахилгаан хангамжийн суурилагдсан хүчин чадлыг 12,6мВт-аас 42 мВт болгож суурилагдсан хүчин чадлыг 3 дахин нэмэгдүүлэх ажлыг 100 хувь хэрэгжүүлж дууссан.

“Жаргалтай амьдрал” Сэтгэц нийгмийн сэргээн засах эмчилгээний төв нь 2025 онд Архины донтолттой буюу F10 оноштой иргэдэд зориулсан 15 өдрийн клиник, сэтгэлзүй, нийгмийн үйлчилгээний сэргээн засах үндсэн хөтөлбөр болон архаг ядаргаа, стрессийн хөтөлбөр хэрэгжүүлж, Эрүүл мэндийн сайдын 2022 оны 12-р сарын 30-ний өдрийн А/814-р тушаалын хавсралтын дагуу эрэмбэлэн ангилж, эхний хагас жилийн байдлаар 71 хүнд үйлчилгээ үзүүлснээс Архины хамааралтай 59 хүнийг нөхөн сэргээх хөтөлбөрт хамруулсан. 2021-2024 онд үйлчлүүлсэн иргэнээс 2024 оны 08 сард түүврээр 130 хүнд хяналт хийхэд нөхөн сэргээгдсэн 16%, дахилтын зай холдсон 45%, дахилт өгсөн 34% байна. Сүүлийн 5 жилийн хугацаанд Архины хамааралтай 690 иргэнийг нөхөн сэргээх хөтөлбөрт хамруулсан.

“Баянхонгор тохижилт” ОНӨТБ тайлант оны эхний хагас жилийн байдлаар 500 мквт талбайд 1600 ширхэг гоёлын мод, ойн зурвасуудад 1900 ширхэг нийт 3500 ширхэг мод бут сөөгийг нөхөн тариалсан. Үүнд:

1.Онцгой байдлын уулзвараас Номгон ахлах сургууль хүртэлх замын урдуур 800 ширхэг хайлаас, 450 ширхэг агч,

2.Амьчуулын тойргийн замын хоёр талаар 300 ширхэг хайлаас,

3.Тусгаарлах зурвас дунд 63 ширхэг, 60 ширхэг голт бор,

4.Төв гандангийн урд 50 ширхэг агч,

5.Оготнотой булгийн замын хажуугаар 50 ширхэг улиас,

6.Ойн зурваст 500 ширхэг улиас, 450 ширхэг бургас,

7.Нарст гудамжид 20 ширхэг агч,

8.Голын захын ойн зурваст 600 ширхэг улиас, 400 ширхэг бургас тариалж, мод, бут сөөгний ургалтын хувийг 79 хувьд хүргэж өмнөх оны энэ үеэс 2 хувиар нэмэгдүүлсэн.

“Сум дундын ойн анги” ОНӨААТҮГ нийт 100,000 ширхэг модны тарьц суулгацыг үржүүлэн, бойжуулах зорилт дэвшүүлж, Бургас модны тарьц суулгац 60,000 ширхэг, Улиас модны тарьц суулгац 40,000 ширхэгийг тус тус үржүүлэн, бойжуулсан. Тарьц суулгацын төрөл зүйлийг нэмэгдүүлэх зорилгоор 2000 ширхэг сухай модны мөчрийн тайраадсыг үржүүлсэн. Модны үрээр үрслүүлэг хийх ажлыг төлөвлөж, 6х20 хэмжээтэй 6 хүлэмжид 8 нэр төрлийн модны үрээр үрслүүлэг бойжуулах ажлыг үе шаттайгаар хэрэгжүүлсэн. Үүнд: гүйлс, монос, шар хуайс, жигд, агч, голт бор, хайлаас, туулайн бөөр зэрэг моддын үрийг сонгон ашигласан бөгөөд эдгээр нь орон нутгийн нөхцөлд зохицон ургах чадвар сайтай, ойжуулалт, ногоон байгууламжийн хэрэгцээнд нэн тохиромжтой суулгацыг бойжуулсан.

“Цэвэр хот” ОНӨААТГ хогийн цэг дээрээс тогтмол төмөр, зэс, хөнгөн цагаан, лааз, хувцанцар зэрэг 5 төрлийн хогийг ангилж, төмөр 6тн*150₮, лааз 250кг*2000₮, зэс 50 кг*20000₮, хөнгөн цагаан 125кг*4000₮-өөр ангилан тушааж эдийн засгийн эргэлтэд оруулан сард 2,9 сая төгрөгийн орлогыг олсон бөгөөд 5 дугаар сарын байдлаар төмөр 30 тн, лааз 1250 кг, зэс 250 кг, хөнгөн цагаан 625 кг-ийг ангилсан хоёрдогч түүхий эдийг хүлээн авах цэгт нийлүүлж ажилласан байна.

Бусад төрөлжүүлэн ангилсан хаягдал тос масло, аккумулятор, машины бүхээг, хуванцарыг сүүлийн хагас жилд холбогдох газруудад нийлүүлэхээр бэлтгэл ажил шат дараатай хийгдэж байгаа.

“Баянхонгор үйлдвэржилт корпораци” ХХК 2024 онд нийт 23 иргэн, ААН-д 2 захирамжаар 215,000,000 төгрөгийн зээлийг олгосон байна. Төсөл хэрэгжүүлэхээс өмнө 39 иргэн ажиллаж байсан бол төсөл хэрэгжүүлснээс хойш 67 буюу шинээр 28 иргэн байнгын ажлын байраар хангагдаад байна. Гэрээт /түр ажилтан/ 14 иргэн ажлын байраар хангагдсан. Нийт 67 иргэнээс 8 иргэн НДШ төлж, хөгжлийн бэрхшээлтэй 1 иргэн ажиллаж байна. Үүнээс 15 иргэн ААН нь өөрийн ажлын байртай, 8 иргэн ААН түрээсийн ажлын байраар хангагдсан. 20 иргэн ААН байнгын үйл ажиллагаатай, 3 иргэн ААН улирлын чанартайгаар үйл ажиллагаа явуулж байгаа зэрэг үр дүн гарсан байна.

Хүснэгт 11. Байгууллагын тэргүүлэх ач холбогдолтой шалгуур үзүүлэлтийн үнэлгээний дүн:

Д/д	Төрийн болон Орон нутгийн өмчийн байгууллагууд	Байгууллагын тэргүүлэх ач холбогдолтой арга хэмжээний шалгуур үзүүлэлтийн үнэлгээ
1	2	3
1	Автотээврийн төв	82.5%
2	Баянхонгор тохижилт ОНӨТБ	57.5%
3	Баянхонгор Эрчим хүч, цахилгаан түгээх ХХК	100%
4	Бөөнцагаан-Орог нуурын сав газрын захиргаа	94%

5	“Жаргалтай амьдрал” сэтгэц нийгмийн сэргээн засах эмчилгээний төв	100%
6	Их Богдын байгалийн цогцолборт газрын хамгаалалтын захиргаа	100%
7	Сум дундын ойн анги ОНӨААТҮГ	90%
8	Цэвэр хот ОНӨААТҮГ	95%
9	Чандмань Баянхонгор ЖК	100%
10	Баянхонгор үйлдвэржилт хөгжлийн корпораци	96.67%
11	Төрийн цахим үйлчилгээний хэлтэс	0%
Дундаж үнэлгээ		81.72%

Гурав. Дүгнэлт:

Төрийн болон Орон нутгийн өмчийн байгууллагууд нь 2025 оны эхний хагас жилд давхардсан тоогоор 151 хэрэгжилтийн тайлан ирүүлэхээс 11 тайлан буюу 7.3 хувийг хугацаа хоцроосон, 13 тайлан буюу 8.6 хувийг тайлагнаагүй нь өмнөх оны мөн үеэс хоцроосон тайлан 4.3 хувиар буурч, тасалсан тайлан 2.8 хувиар өссөн, тайлан хоцроох зөрчил бүрэн арилаагүй байна.

Бодлогын баримт бичиг, хууль тогтоомж, тогтоол шийдвэр, байгууллагын үйл ажиллагаанд Хяналт-шинжилгээ, үнэлгээ хийсэн дүнгээр 4 байгууллага буюу 36.36 хувь нь “Тодорхой үр дүнд хүрсэн” /өнгөрсөн оны мөн үеэс 1 байгууллагаар буюу 9.04 хувиар буурсан/, 7 байгууллага буюу 63.63 хувь нь “Эрчимжүүлэх шаардлагатай”, /өнгөрсөн оны мөн үеэс 3 байгууллагаар буюу 27.33 хувиар нэмэгдсэн/ 1 байгууллага 0-30 хувь буюу “Үр дүнгүй” гэж үнэлэгдсэн нь өнгөрсөн оны мөн үеэс 1 байгууллагаар буюу 9.09 хувиар буурсан үзүүлэлттэй байна.

Өнгөрсөн оны мөн үетэй харьцуулахад Төрийн болон Орон нутгийн өмчийн байгууллагуудын дундаж үнэлгээ 56.43 хувиас 60.62 хувь болж өссөн үзүүлэлт гарсан байна.

Хүснэгт 12. Төрийн болон Орон нутгийн өмчийн байгууллагуудын 2025 оны эхний хагас жилийн үйл ажиллагааны үнэлгээний дүн:

Байгууллагын нэр	Тайлагнавал зохих тайлангийн тоо	Дундаж үнэлгээ	Хоцроосон тайлангийн тоо	Тасалсан тайлангийн тоо	Ерөнхий үнэлгээ
1	2	3	4	5	6
Автотээврийн төв	13	45.34%	1	2	38.34%
Баянхонгор тохижилт ОНӨТБ	14	84.5%	-	-	84.5%
Баянхонгор Эрчим хүч, цахилгаан түгээх ХХК	14	65.65%	1	2	53.65%
Бөөнцагаан-Орог нуурын сав газрын захиргаа	14	80.8%	-	-	80.8%
“Жаргалтай амьдрал” сэтгэц нийгмийн сэргээн засах эмчилгээний төв	14	74.2%	1	1	67.2%
Их Богдын байгалийн цогцолборт газрын хамгаалалтын захиргаа	13	89.13%	1	-	87.13%
Сум дундын ойн анги ОНӨААТҮГ	15	68.2%	-	3	53.2%

Цэвэр хот ОНӨААТҮГ	14	80%	-	1	75%
Чандмань Баянхонгор ХК	15	73.8%	1	1	66.8%
Баянхонгор үйлдвэржилт хөгжлийн корпораци	14	57.77%	5	2	37.77%
Төрийн цахим үйлчилгээний хэлтэс	11	34.52%	1	2	22.52%
Нийт дүн	151	68.53%	11	13	60.62%

**Цахим мэдээллийн сангийн бүртгэлээр хоцроосон, тайлагнаагүй тайланг үнэлгээнд тооцсон болно.*

Тайлангийн чанарт ахиц гарахгүй байгаа шалтгааныг дараах байдлаар тодорхойлж байна.

1.Аймгийн Засаг даргын Тамгын газрын Хяналт-шинжилгээ, үнэлгээний хэлтсийн зөвлөмжийн ирц сайжирсан ч, зөвлөмжөөр өгсөн хэрэгжилт хангалтгүй, хэрэгжээгүй, хугацаа болоогүй заалт тус бүрийг тусгасан нарийвчилсан төлөвлөгөөг боловсруулан хэрэгжүүлээгүй, холбогдох албан тушаалтанд хариуцуулаагүй, хэрэгжилтийн чанарт анхаарахгүй байна.

2.Аймгийн Засаг даргын 2022 оны А/286 дугаар захирамжаар батлагдсан “Бодлогын баримт бичиг, хууль тогтоомж, нутгийн захиргааны байгууллагын үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх журам”-ын дагуу ирүүлээгүй тайлан тус бүрийг 5 оноогоор, хугацаа хоцроосон тайлан тус бүрийг 2 оноогоор тооцон тухайн байгууллагын ерөнхий дундаж онооноос хасаж тооцох зохицуулалтыг анхаарч үздэггүй.

3.Тайлангийн чанарт анхаарахгүй үр дүнг тайлагнахгүй, болсон үйл явдлыг тоочиж хүүрнэсэн, нэг хэрэгжилтээр олон заалтыг тайлагнасан, алба хаагчдын ажилдаа хандах хандлага, сахилга, хариуцлага суларсан, төлөвлөсөн арга хэмжээний хүрээнд тодорхой ажил зохион байгуулдаггүй, удирдлага зохион байгуулалт, удирдлагын хяналт муу байгаатай холбоотой гэж үзэж байна.

Хүснэгт 13. Байгууллагуудын 2025 оны эхний хагас жилийн үнэлгээг өмнөх оны мөн үетэй харьцуулбал:

Байгууллагын нэр	2023 оны хагас жилийн үнэлгээ	2024 оны хагас жилийн үнэлгээ	Өөрчлөлт	2024 оны хагас жилийн үнэлгээ	2025 оны хагас жилийн үнэлгээ	Өөрчлөлт
1						
Автотээврийн төв	29.93%	7.3%	37.23	7.3%	38.34%	31.04
Баянхонгор тохижилт ОНӨТБ	52.6%	69.5%	16.9	69.5%	84.5%	15
Баянхонгор Эрчим хүч, цахилгаан түгээх ХХК	6.71%	77.1%	70.39	77.1%	53.65%	-23.45

Бөөнцагаан-Орог нуурын сав газрын захиргаа	19.7%	71.5%	51.8	71.5%	80.8%	9.3
"Жаргалтай амьдрал" сэтгэц нийгмийн сэргээн засах эмчилгээний төв	26.5%	57.6%	31.1	57.6%	67.2%	9.6
Их Богдын байгалийн цогцолборт газрын хамгаалалтын захиргаа	46.51%	89.3%	42.79	89.3%	87.13%	-2.17
Сум дундын ойн анги ОНӨААТҮГ	14%	30.1%	16.1	30.1%	53.2%	23.1
Цэвэр хот ОНӨААТҮГ	25.5%	75.7%	50.2	75.7%	75%	-0.7
Чандмань Баянхонгор ХК	73.6%	70%	-3.6	70%	66.8%	-3.2
Баянхонгор үйлдвэржилт хөгжлийн корпораци	-47.3%	51.5%	98.8	51.5%	37.77%	-13.73
Төрийн цахим үйлчилгээний хэлтэс	-	21.2%	21.2	21.2%	22.52%	1.32
Нийт дүн	18.8%	56.43%	37.6	56.43%	60.62%	4.19

Хяналт-шинжилгээ, үнэлгээний дүнгээр аймгийн 2025 оны жилийн хөгжлийн төлөвлөгөөний хяналтад аваагүй заалтууд, байгууллагын гүйцэтгэлийн төлөвлөгөөний хэрэгжилтийн үнэлгээгээр үр дүнгүй, эрчимжүүлэх шаардлагатай гэж үнэлэгдсэн арга хэмжээ, хууль тогтоомж, тогтоол шийдвэр, аймгийн Засаг даргын захирамж, албан даалгаврын хэрэгжилт хангалтгүй, хэрэгжээгүй, хугацаа болоогүй заалт тус бүрийг хяналтад авч, хэрэгжилтийн байдалд дүгнэлт хийх, хэрэгжилтийг бүрэн хангах арга хэмжээ авч хэрэгжүүлэх, үйл ажиллагааны удирдлага, зохион байгуулалтыг сайжруулж, сахилга хариуцлагыг дээшлүүлж ажиллах нь зүйтэй байна.

Байгууллагын 2025 оны эхний хагас жилийн үйл ажиллагааны үр дүнгээр "50 хувь"-иас доош үнэлгээ авсан Автотээврийн төв, Баянхонгор үйлдвэржилт хөгжлийн корпораци, "Төрийн цахим үйлчилгээний хэлтэс" нь үйл ажиллагаагаа сайжруулах төлөвлөгөөг тус тус боловсруулан хэрэгжүүлж, үр дүнг эрчимжүүлэх шаардлагатай.

ХЯНАСАН:
ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭНИЙ
ХЭЛТСИЙН ДАРГА

ТАЙЛАН БИЧСЭН:
ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭНИЙ
ХЭЛТСИЙН МЭРГЭЖИЛТЭН



Т.ЭРДЭНЭБАТ

Э.МӨНХТУЯА

**ТӨРИЙН БОЛОН ОРОН НУТГИЙН ӨМЧИЙН БАЙГУУЛЛАГУУДЫН 2025 ОНЫ ЭХНИЙ ХАГАС ЖИЛИЙН
ҮЙЛ АЖИЛЛАГААНД ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭ ХИЙСЭН ДҮН**

2025 оны 08 дугаар сарын 20

Номгон

Байгууллагууд		Баянхонгор аймаг Автотээврийн төв	Баянхонгор Тохижилт үйлчилгээ ОНӨААТҮГ	Баянхонгор Эрчим хүч ЦТХХК	Бөөнцагаан-Орог нуурын сав газрын захиргаа	Жергалтай амьдрал сэтгэц нийгмийн сэргэн засах эмчилгээний төв*	Их Богдын байгалийн цогцолборт газрын хамгаалалтын захиргаа	Сум дундын ойн анги	Цэвэр хот ОНӨААТҮГ	Чандмань- Баянхонгор ХК	Баянхонгор үйлдвэржилт хөгжлийн корпораци ОНӨҮГ	Төрийн цахим үйлчилгээний хэлтэс	
Үзүүлэлт		Хувь	Хувь	Хувь	Хувь	Хувь	Хувь	Хувь	Хувь	Хувь	Хувь	Хувь	
1	2	3	4	5	6	7	8	9	10	11	12	13	
	1.Аймгийн жилийн хөгжлийн төлөвлөгөө	0%	100%	0%	73%	50%	*	0%	0%	0%	0%	0%	
	2.Дэд хөтөлбөр	90%	97.5%	50%	80%	90%	100%	90%	95%	70%	*	*	
	3.Хууль тогтоомж, тогтоол, шийдвэр	60%	83%	100%	86%	100%	100%	100%	100%	100%	80%	80%	86%
	4.ИТХ, ИТХТ-ийн тогтоол	100%	100%	100%	100%	*	100%	100%	100%	100%	100%	100%	0%
	5.Засаг даргын захирамж, албан даалгавар	79%	100%	100%	100%	100%	100%	100%	100%	100%	83%	100%	0%
	6.Байгууллагын гүйцэтгэлийн төлөвлөгөөний хэрэгжилт	0%	89.69%	*	85.32%	85.83%	85%	0%	85.64%	72.31%	67.42%	0%	
	7.Төрийн албан хаагчийн сургалт, ажиллах нөхцөл, нийгмийн баталгааны хөтөлбөрийн биелэлт	61.43%	75.71%	85.71%	71.43%	100%	75.71%	85.71%	100%	68.57%	0%	62.86%	
	8.Архив, албан хэрэг хөтлөлтийн үнэлгээ	0%	80%	80%	100%	0%	80%	80%	80%	80%	80%	80%	*
	9.Зөвлөмжийн хэрэгжилт	12.86%	88.33%	25%	76.67%	100%	100%	100%	78.33%	78.33%	83.33%	42.86%	
Байгууллагын нээлттэй байдлын үнэлгээ	10.Байгууллагын ил тод байдлын үнэлгээ	41.18%	61.67%	91.54%	34.23%	57.92%	86.8%	41.74%	28.61%	68.15%	34.67%	98.29%	
	11.Шилэн данс	*	83.33%	63.98%	*	98.47%	*	64.37%	81.8%	99.62%	45.02%	*	
Засгийн газрын тэргүүлэх чилгээ	12.Тэрбум мод	0%	100%	0%	100%	0%	100%	100%	100%	59.49%	0%	0%	
	13.Цахим шилжилт	62.49%	66.42%	74.45%	65.08%	62.06%	81.2%	70.97%	74.96%	80.12%	71.67%	*	
	14.Байгууллагын тэргүүлэх ач холбогдолтой шалгуур үзүүлэлтийн үнэлгээ	82.5%	57.5%	100%	94%	100%	100%	90%	95%	100%	96.67%	0%	
	15.Сайдтай байгуулсан гэрээний хэрэгжилт	*	*	48.47%	65.71%	95%	50%	0%	*	67.5%	50%	89.78%	
Дундаж үнэлгээ:		45.34%	84.5%	65.65%	80.8%	74.20%	89.13%	68.2%	80%	73.8%	57.77%	34.5%	
Хасах оноо		7	*	12	*	7	2	15	5	7	20	12	
Ерөнхий үнэлгээ		38.34%	84.5%	53.65%	80.8%	67.2%	87.13%	53.2%	75%	66.8%	37.77%	22.52%	